

НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

“Нийтийн сонсголын тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлгийг Нээлттэй Нийгэм Форум нь УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөлтэй хамтран 2014 оны 10 дугаар сард зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн явцад оролцогчид хуулийн төслийн үзэл санааг дэмжихийн зэрэгцээ зорилт, зохицуулах зүйл, нэр томъёо, хэл найруулга, нийтлэг шаардлагад хамаарах асуудлаар санал шүүмж гаргасныг нэгтгэн танилцуулж байна.

Төрийн бус байгууллага (ТББ) болон нутгийн захиргааны байгууллагын өргөн оролцоотойгоор хэлэлцэж томъёолсон эдгээр саналыг хуулийн төсөлд тусгахгүй бол энэхүү хууль нь тунхаглалын чанартай болж ардчилсан, сайн засаглалын чухал үйл явц болох нээлттэй сонсгол болон иргэдийн оролцоог жинхэнэ утгаар нь төлөвшүүлэх нөхцөл хангагдахгүй болж болзошгүйг онцлон тэмдэглэж байна.

Нийтийн сонсголын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Ч.Батзул, Д.Нарангэрэл (Баянгол дүүргийн ИТХ), П.Мөнхзул, Д.Нямгэрэл, Б.Хандсүрэн (Хан-Уул дүүргийн ИТХ), Ч.Мөнхсайхан, Д.Нэргүй, Г.Энхтайван (Баянзүрх дүүргийн ИТХ), Засаг даргын тамгын газраас Б.Ганбаатар, Г.Долормаа (Сүхбаатар дүүргийн ЗДТГ), А.Пүрэвсүрэн (Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ), олон улсын байгууллагаас Жак Мерат, А.Мандухай (Швейцарийн хөгжлийн агентлаг), П.Жаргалсайхан (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр), Г.Золжаргал, Н.Лувсанжав (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл), төрийн бус байгууллагаас С.Айнагүл (Казах эмэгтэйчүүдийн Арулар холбоо), Б.Алтантуяа (Монголын Эмнести Интернэшнл), С.Баярмаа, Ж.Даваасүрэн, М.Заяа (судлаач, өмгөөлөгч), Я.Ганчимэг (Хүйсийн тэгш эрхийн төв), Ш.Жаргалсайхан (Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо), Г.Золжаргалан (Хүний аюулгүй байдлын судалгааны төв), Д.Мөнхбүрэн, Ч.Энхбаяр (Глоб Интернэшнл Төв), А.Мөнхнаран (Сонгогчдын боловсрол төв), Ц.Оюунбаатар (Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо), С.Оюунтуяа (Сонгогчдын боловсрол төв), Г.Пагма (Дэлхийн Банк), Д.Сүхжаргалмаа (Монфемнет Үндэсний сүлжээ, Иргэдийн алъяанс төв), Ц.Туяацэцэг (Туул голоо хамгаалах үндэсний хөдөлгөөн), С.Цэрэнпүрэв (Захиргааны шинэ санаачлага), М.Чинзориг (Монголын Эрэгтэйчүүдийн Холбоо), С.Энхжаргал (MIDAS), Ч.Энхжаргал (Зориг сан) болон Б.Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцлоо.

Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

1. Хуулийн төсөлд “сонсгол гэж юу болох, сонсголын төрлүүд, сонсголыг хэн хийх, хэзээ хийх, ямар сэдвийн хүрээнд хийх” зэргийг заасан ч сонсгол зохион байгуулах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулаагүй байна. Процессийг нарийн зохицуулж тусгаагүй тохиолдолд энэ хууль нь тунхаглалын шинжтэй, хэрэгждэггүй хууль болж болзошгүй.

Санал: Сонсгол зохион байгуулах үйл ажиллагааг “сонсголын өмнө, сонсголын үед, сонсголын дараа” хэмээн ангилж, үе шат бүрийн нарийвчилсан зохицуулалтыг (процессжуулах) хуулийн төсөлд тусгах.

- Хуулийн төсөл 28 зүйлтэй ба үүнээс 8 зүйл, 9 заалтад тухайн асуудлаар журам гарган тусгайлан зохицуулахыг өөр бусад байгууллагад үүрэг болгожээ. Энэ нь нийтийн сонсгол зохион байгуулах явцад хуулийн зорилго, зарчмыг “гажуудуулах, бүдгэрүүлэх” эрсдэл үүсгэнэ.

Санал: Хуулийг дагаж гарах журмын ерөнхий үзэл баримтлал, зарчим, зохицуулах зүйлийг хуульд тодорхой заах.

- Хуулийн төслийн 19.6-д “Хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, томилгооны болон мөрдөн шалгах сонсголын нарийвчилсан журмыг Улсын Их Хурал, захиргааны сонсголын нарийвчилсан журмыг Засгийн газар батална” гэж заасан тул эдгээр журмын төслийг хуулийн төсөлтэй хамт хэлэлцвэл хууль, журмын уялдаа болон хуулиар зохицуулаагүй асуудлыг журмаар бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг хянаж, нарийн уялдуулах боломж бий болно.
- Хуулийн төсөлд хууль тогтоох байгууллагаар батлагдаж хүчин төгөлдөр болоогүй хуулийг иш татсан¹ нь цаашид төслийг хэлэлцэхэд тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож байна.
- Шийдвэр гартгах, хэрэгжилтийг хянах, албан тушаалтнуудыг томилох зэрэгт иргэдийн оролцоог хангах хуулийн зарчмуудыг томъёолсон ч эдгээр зарчим нь хуулийн зохицуулалт, холбогдох зүйл, заалтад тусгалаа олоогүй байна.

Тэгш оролцоог хангах зарчим байгаа ч хязгаарлалтууд тавигдсан.

- Төсвийн хяналтын сонсгол дээр “аливаа этгээд” хүсэлт гаргах эрхгүй, зөвхөн төр өөрөө санаачлагч нь байна (9-р зүйл).
- Орон нутгийн сонсгол дээр нутгийн иргэд, орон нутгийн ТББ, аливаа этгээд хүсэлт гаргах боломжгүй (12-р зүйл).
- “Сонсголд оролцогч” гэдэгт гэрч, шинжээч, ажиглагч, хүсэлт гаргасан иргэн байгаа бөгөөд мэдээлэл, тайлбар хийх албан тушаалтан багтаагүй (13.1 дэх заалт).
- Ерөнхий хяналтын сонсгол дээр “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй” гэдгээ нотлох ёстой бөгөөд тэднийг төлөөлөн хүсэлт гаргах боломжгүй байна (8.2.4, 8.3.2 дахь заалт).
- Уг хуулийн төсөлд үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг тусгай хэрэгцээт бүлгийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт байхгүй учраас тэгш эрх, оролцооны зарчим бүрэн хангагдсан гэж үзэх боломжгүй.

Иргэний мэдэх эрхийг хангах зарчим байгаа ч хязгаарлалтууд тавигдсан байна.

- “Сонсголын товыг тогтооно” гэж заасан нь хангалтгүй бөгөөд ямар сэдвээр, хаана, хэн, хэзээ зохион байгуулах, хэрхэн бүртгүүлэх, хэн оролцож болох гэх мэт дэлгэрэнгүй зохицуулалт тусгах шаардлагатай юм (21.1 дэх заалт).
- Сонсголын тэмдэглэл хаалттайгаас бусад тохиолдолд нээлттэй байна гэсэн ч ямар арга, хэлбэрээр, хэн, хэзээ нийтэд ил болгох вэ гэдэг нь тодорхойгүй (20.2 дахь заалт).
- Сонсголын үе шат бүрт иргэд хэрхэн оролцох талаар тодорхой зохицуулалт байхгүй, ямар нэг эргэх холбоогүй.

- Хуулийн төслийг сайжруулах зорилгоор дараах тодорхой саналыг гаргаж байна.

Санал: • Нийтийн сонсголын тухай хууль тогтоомж гэсэн хэсэгт холбогдох хуулиудыг тусгах шаардлагатай байна.

¹ Хуулийн төслийн 21.3.5-д Захиргааны ерөнхий хууль, 27.2-т Сонгогдсон болон Улсын Их Хурлаас томилогдсон төрийн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуульд... г.м

- Санал:**
- Хуулийн төслийн нэр томъёо хэсэгт “иргэдийн оролцоо”-г юу гэж ойлгохыг тайлбарлах шаардлагатай. Үүний тулд бодитой оролцооны үндсэн бүрэлдэхүүн болох мэдээлэлтэй, саналаа бэлтгэж амжихуйц хугацаатай, саналаа хэлэх арга зам нь тодорхой, үгээ хэлж оролцох боломжтой, хэлсэн саналыг нь тусгасан эсэхийг хариу мэдээлдэг байх зэргийг багтаан тайлбарлах. Эс бөгөөс “оролцох” нь “байлцах”-тай утга нэг болж “иргэдийн оролцоо” гэх ардчилсан засаглалын нэгэн үндсэн ухагдахууны утга учир алдагдахад хүрнэ.
 - Нийтийн сонгогч хийх хүсэлт гаргасан этгээдийг хэрхэн сонгох ерөнхий зарчмыг хуулийн төсөлд тусгах.
 - ТББ нь нийтийн сонгогчийн нэг субъект байхаар тусгах.
 - Хууль тогтоох үйл явцыг хуулиар тусгайлан зохицуулдаг тул “Хууль тогтоох сонгогч”-ын нарийвчилсан зохицуулалтыг тухайн хуулиар зохицуулахаар заах.

7. Хуулийн төслийн 6.3-т нийтийн сонгогчийг “үндэсний аюулгүй байдлыг хангахтай” холбоотой хаалттай явуулахаар заасан нь зайлшгүй нөхцөл мөн эсэхийг нягтлах шаардлагатай. “Төрийн нууцын тухай хууль”-ийн дагуу энэ асуудал зохицуулагдах боломжтой.
8. Хуулийн төсөлд нийтийн сонгогч явуулах тухай хүсэлт гаргах эрхтэй этгээдийн хүсэлтийг эрх бүхий байгууллага хүлээж аваагүй тохиолдолд хэрхэхийг тодорхой заагааргүй.

Санал: Нийтийн сонгогч явуулах хүсэлтийг хүлээн авахгүй байх үндэслэл, журмыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах.

9. “Хууль тогтоох сонгогч”-ыг заавал явуулах үндэслэлд зайлшгүй байх нөхцлүүд бүрэн тусгаагүй байна.

Санал: Хуулийн төслийн 7.1.3-т “төрийн байгуулал, улс төрийн тогтолцоо, сонгуульд хамаарах асуудлыг шийдвэрлэх” гэж нэмж тусгах.

10. “Ерөнхий хяналтын сонгогч”-оор ямар асуудлыг хэлэлцэх талаар хуульд тодорхой заагаагүй байна.

Санал: “Ерөнхий хяналтын сонгогч”-ын “төсвийн хяналтын сонгогч”, “мөрдөн шалгах сонгогч”-оос ялгарах онцлогийг тусгах.

11. Хуулийн төслийн 8.5-д заасан ажил мониторинг, хяналт шинжилгээгээр хийгддэг тул төрийн байгууллагад ажлын давхцал бий болж байна. Энэ нь үр ашиггүй зардал, нэмэлт ажлын ачаалал бий болгож болзошгүй.
12. “Төсөв, татвар батлах, тэдгээрийн зарцуулалтад хяналт тавих” нь нийтийн сонгогч зохион байгуулах нэг асуудал гэж хуулийн төслийн 4.2.4-т заасан ч 9-р зүйлд зөвхөн төсвийн биелэлт, зарцуулалтын асуудлаар нийтийн сонгогч хийхээр зохицуулсан байна.

Санал: Төсөв батлах үе шатад нийтийн сонгогч хийх шаардлагатай тул нэмж тусгах. Харин “татвар батлах” гэдгийг хасах.

13. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т “мөрдөн шалгах сонсгол”-ыг “... Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлаас томилогдсон албан тушаалтны хууль зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор зохион байгуулж болно” гэж заасан байна. Эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн аливаа этгээдэд хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжид хариуцлагыг захиргааны, эрүүгийн гэж ангилдаг. Хэрвээ “Мөрдөн шалгах сонсгол”-ын зорилго нь “хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх” бол энэ тухай нарийвчлан зохицуулах шаардлагатай. Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.8-д “Мөрдөн шалгах түр хорооны дүгнэлтийг шүүх хянахгүй” гэж заасан нь албан тушаалтан хариуцлагаас бултаж болзошгүй нөхцлийг бүрдүүлж болох юм. Учир нь тухайн албан тушаалтныг мөрдөн шалгах сонсголд орсон гэх үндэслэлээр гэмт хэргийн шинжтэй үйлдлийг дарагдуулан өнгөрүүлэх боломж нээлттэй байна.

Санал: “Аливаа албан тушаалтныг мөрдөн шалгах сонсголоор оруулж, дүгнэлт гаргасан нь хууль зөрчсөн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх” зарчмыг хуулийн төсөлд тодорхой тусгах.

14. Тус хуульд “нээлттэй хэлэлцүүлэг”-ийг “нийтийн сонсгол”-той андуурч оруулсан байж болзошгүй. Тухайлбал, “томилгооны сонсгол”-ын зохицуулалт нь тодорхой албан тушаалд нэр дэвшиж байгаа хүнийг нээлттэй хэлэлцүүлгээр оруулж, хэлэлцүүлэхээс ялгаатай эсэх нь тодорхойгүй байна. Хэрвээ үүнийг нийтийн сонсгол хэлбэрээр зохион байгуулах бол иргэд, тодорхой бүлгүүд зөвхөн сонсогчийн байр суурьнаас биш санал, бодлоо хэлж оролцох ёстой.

15. “Томилгооны сонсгол”-ыг гишүүдийн хүсэлтийн дагуу хийхээр зохицуулсан нь оновчтой биш юм.

Санал: Гиймээс “томилгооны сонсгол”-ыг заавал хийдэг байх, мөн даргалагчийг сөрөг хүчнээс томилох тухай зохицуулалт нэмж тусгах.

Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Санал, дүгнэлт

Зүйл, заалтыг өөрчлөн найруулах

1	Хуулийн төслийн 1-р зүйлд “...төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад...” гэснийг “...төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн бодитой оролцоог хангах замаар бодлого, шийдвэрийг чанаржуулахад оршино” гэсэн байдлаар томъёолох	Өмнөх томъёолол нь хэт тунхаглалын шинжтэй тул
2	5.1.3 “... баримт сэлт цуглуулах” гэснийг “... мэдээлэл түүнтэй холбоотой баримт цуглуулах” гэж найруулах	Утга, агуулгыг сайжруулсан
3	6.1-ийн найруулгыг засч сайжруулах	
4	6.2.4, 10.3 “мөрдөн шалгах” гэснийг “хянан шалгах” гэх байдлаар өөрчлөх	Мөрдөн шалгах гэж нэрлэх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны “мөрдөх” гэсэн ойлголттой ижил утгаар ойлгогдож байна.
5	6.3. Хуульд нууц гэж зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.	Өмнөх заалт нь сонсголыг хаалттай явуулах өргөн эрхийг олгосон.
6	6.2.1 “Хууль тогтоох сонсгол” гэснийг “хууль тогтоохтой холбогдох сонсгол” гэх байдлаар өөрчлөх	Хууль зүйн шууд үр дагаварт хүргэх мэт ойлгогдож байна.
7	7.1 “... дараах тохиолдолд хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлтэй холбогдуулан нээлттэй сонсголыг заавал явуулна” гэж өөрчлөх	
8	7.3 “... аливаа этгээд” гэснийг “иргэн, хуулийн этгээд” гэж өөрчлөх, “... байнгын ба дэд хороонд” гэснийг “байнгын хороонд” гэж өөрчлөх	

9	8.7. “... Хүний эрхийн үндэсний комиссоор дүгнэлт гаргуулж болно” гэж заасныг “гаргуулна” гэж өөрчлөх	Хүний эрхийн асуудлаар нээлттэй сонсгол хийж буй тохиолдолд энэ чиглэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг төрийн байгууллагын оролцоо заавал байх ёстой. Түүнчлэн “энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар дүгнэлт гаргуулж болно” гэж нэмж болох.
10	9.3. “... орон нутгийн” гэснийг “нутгийн захиргааны” гэж өөрчлөх	Нутгийн захиргааны гэх нэршил нь Үндсэн хуульд заасан нэршил юм.
11	10. 2 “... зөрчсөн эсэхийг тогтоох” гэснийг “... зөрчсөн эсэхтэй холбоотой асуудлыг тодруулах, мэдээлэл авах” гэж өөрчлөх	
12	10.4 “сонсголоор хэлэлцэх баримт сэлтийг цуглуулах” гэснийг “сонсгол зохион байгуулж, мэдээлэл цуглуулах” гэж өөрчлөх	
13	10.6 “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа асуудлаар УИХ мөрдөн шалгах сонсгол явуулахгүй” гэж өөрчлөх	
14	10.7-д мөрдөн шалгах сонсгол явуулах хүсэлтийг “Улсын Их Хуралд” гэснийг тодорхой субъект болгож өөрчлөх.	Хэнд гаргах нь тодорхойгүй байна.
15	16.1.2. “Сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах” гэдгийг “Сонсголын тэмдэглэл, гарсан шийдвэр, дүгнэлтийг ажлын 5 хоногт багтаан танилцуулна” гэж өөрчлөх	Хэрэв хугацаа тогтоож өгөхгүй бол сонсгол дууссаны дараа шийдвэр гаргахгүй хугацаа алдах боломж бүрдэнэ.
16	16.2.4. “... үнэн бодитой байх” гэснийг “... үндэслэлтэй” байх гэж өөрчлөх	Тайлбар, санал, дүгнэлтийг үнэн гэж үнэлэх бус үндэслэлтэй эсэхийг харгалзан үзэх ёстой.
17	10.7, 5.1, 8.2.4, 8.3.2, 8.2.4, 8.4, 7.3, 8.8, 15.2 эдгээр зүйлд сонсголд оролцогчдыг иргэн, аливаа этгээд, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй боловч сонсголд зайлшгүй оролцуулах шаардлагатай бусад гэх мэт өөр өөрөөр заасан байна.	Нэр томъёоны зөрүүтэй байдлыг арилгах
18	6.2.6-д “захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн сонсгол” гэж заасан атлаа 19.6-д “захиргааны сонсгол” гэж нэг ойлголтыг өөр өөрөөр тодорхойлсон.	
19	19.2 “... тусгаж болно” гэснийг “... тусгана” гэж өөрчлөх	Сонсголын сэдэвтэй холбогдуулж ирсэн санал, хүсэлтийг тэмдэглэлд тусгаж баримтжуулах шаардлагатай.
20	19.4 “нээлттэй сонсголд” гэсний дараа “... олон нийтийн” гэж нэмэх	Утга, агуулгыг сайжруулсан
21	22.2. “... зарыг бичгээр буюу бусад нотлогдох боломжтой арга хэрэгслээр хүргүүлнэ” гэснийг “зарлан дуудах хуудсаар хүргүүлнэ” гэж өөрчлөх	Иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар аливаа этгээдийг шүүх хуралд дуудахдаа “зарлан дуудах хуудас” хүргүүлдэг.

Зүйл, заалт нэмж, хасах

22	3.1. “үл алагчлах, хүртээмжтэй” байх гэсэн зарчмыг нэмэх	
23	5.1-ээс “олон нийтийн оролцоог хангах” гэснийг хасах	Уг санаа бүхэлдээ орсон бөгөөд давтагдаж байгаа тул
24	Хуулийн төслийн 5.1.4-т “мэргэжлийн холбоо”-г тайлбарласныг хасах	
25	Хуулийн төслийн 8.4.2-оос “...сонсголыг зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх” гэснийг хасах.	Энэ нь иргэн, хуулийн этгээдэд илүүц шаардлага болсон.

26	9 дүгээр зүйл “төсвийн хяналтын сонсгол явуулах хүсэлтийг иргэд гаргах эрхтэй байх” зохицуулалтыг нэмж тусгах	
27	9.3.1. “Халамжийн сангийн зарцуулалтын талаар сонсгол явуулах” тухай зохицуулалтыг нэмэх	
28	10.7. “Монгол Улсын иргэн ...” гэсний дараа “хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд” гэж нэмэх	Хувь хүн ганцаараа санал гаргах бус хуулийн этгээд өөрийн нэрээр хүсэлт гаргах тохиолдол байж болно.
29	10 дугаар зүйл: Мөрдөн шалгах сонсгол нь зөвхөн Улсын Их Хурлын түвшинд хэрэгжихээр байна. Засаг дарга болон орон нутгийн байгууллагад мөрдөн шалгах сонсгол явуулах эрхийг олгох	
30	10 дугаар зүйл: Мөрдөн шалгах сонсголоос цугларсан баримтыг хариуцлага тооцох зорилгоор эх сурвалж болгон ашиглаж, шалгадаг байх	
31	11.3 “... Улсын их хурал” гэсний өмнө “Ерөнхийлөгч” гэж нэмэх	
32	11 дүгээр зүйл: Орон нутгийн сонсголд иргэний хүсэлт гаргах боломжийг олгох, тодорхой тоо заах, гарын үсэг цуглуулах замаар баталгаажуулах	
33	11 дүгээр зүйлд “Захиргааны сонсгол”-ын тухай зохицуулалтыг нэмэх	Хуулийн төсөлд сонсгол тус бүрийг тухайлан зохицуулсан атлаа захиргааны сонсголыг зохицуулаагүй.
34	14.1. Мэргэжлийн холбоо, Төрийн бус байгууллагад сонсгол санаачлах эрхийг олгох	
35	15.2. Аливаа сонсголд “эрх зүйн чадамжгүй этгээд”-ийг оролцуулах боломжийг олгох, эсхүл хөтөч, хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусламжтайгаар оролцуулах боломж олгох	
36	17 дугаар зүйл: Сонсгол зохион байгуулагчийн эрх, үүргийг нарийвчлан тусгах	
37	18 дугаар зүйл: Сонсгол даргалагчийн эрх үүрэг болон түүнийг хэрхэн сонгох талаар нарийвчлан тусгах, сонсгол даргалагчийг сонгохдоо иргэдийг оролцуулах, хөндлөнгийн этгээдээр даргалагчийг сонгох	
38	19 дүгээр зүйл “Сонсголыг зохион байгуулж буй байгууллага, албан тушаалтны буруугаас сонсгол товлосон хугацаандаа хийгдэж чадаагүй бол сонсголыг дахин зохион байгуулахад холбогдон гарсан зардлыг буруутай албан тушаалтнаас гаргуулна” гэсэн заалт нэмэх	Уг хуулийн төсөлд иргэн сонсголд ирээгүй бол хариуцлага хүлээлгэхээр заасан хэдий ч сонсголыг зохион байгуулагчийн буруугаас сонсгол хийгдэж чадаагүй бол хэрхэн шийдвэрлэх хариуцлагын механизм нь байхгүй байна.
39	19 дүгээр зүйл: Орон нутгийн, захиргааны зэрэг сонсголд ирэх ёстой этгээд хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх	
40	22 дугаар зүйл “сонсголын товд сонсгол хэзээ, хаана, ямар сэдвээр болох, холбогдох мэдээллийг хаанаас авах, оролцох хүн ямар хугацаанд, хаана бүртгүүлэх тухай мэдээллийг багтаасан байна” гэсэн заалтыг нэмэх	Сонсголын товд сонсголын тухай тодорхой мэдээллийг тусгасан байх шаардлагатай. Энэ нь сонсголд оролцох иргэн мэдээлээ бүрэн авч, тайлбараа үндэслэлтэй, бүрэн дүүрэн гаргах боломжийг бүрдүүлнэ.
41	12 дугаар зүйлд “орон нутгийн сонсголыг ямар зорилгоор, ямар тохиолдолд явуулахыг тодорхой заах нь зүйтэй”.	
42	13 дугаар зүйлд “сонсголд оролцогчдын бүрэлдэхүүнд иргэн, хуулийн этгээдийг хамруулахаар тусгах”	
43	17 дугаар зүйлд төсөвтэй холбоотой зохицуулалт нэмэх	Улсын төсөвт “сонсгол явуулах”-тай холбоотой зардлыг тогтмол суулгаж, төлөвлөгөөнд оруулж байх шаардлагатай. Төсөвгүй бол хууль хэрэгжихгүй.
44	26.2, 26.3 дугаар зүйлд заасныг хасах	Энэ нь хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй.

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

Дугаарыг хэвлэхэд дэмжлэг үзүүлсэн:
“НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Иргэдийн
оролцоотой хууль тогтоох ажиллагааг
дэмжих нь” төсөл, НҮБХХ

